

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн
8-р ангийн “Хөгжим” хичээлийн “Дуурь” бүлэг сэдвийн даалгаварын сан

8.1a Сонгодог хөгжмийн төрлүүд, идэрхийллийн арга хэлбэр,
онцлогийг тайлбарлах

1. Сонгодог урлагийн төрлүүдийн идэрхийллийн аргыг зөв харгалзуулаарай.



Симфони хөгжим нь хөгжмийн хэлний хэрэглүүрүүд болох аялгууны шинж төрх, өнгө аяс, хэм хэмжээгээр илэрхийлдэг.



Дуурийн урлаг нь гол дүрүүдийн дотоод сэтгэлийг дуулаачийн төрлөөр илэрхийлдэг.



Бүжгэн жүжгэн нь хүний сэтгэлийн ертөнцийг хөгжмийн хөг аялгуу, хэм хэмнэлд тохируулан уян налархай уран хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

2. Сонгодог урлагийн төрлүүдийн онцлогийг тодорхойлоорой.

2.а гэх мэт урлагийн олон төрлүүд нийлж бүтсэн дуурь хэмээх энэхүү төрөл нь XVI-XVII зууны зааг дээр Италид үүссэн.

а. кино урлаг б. бүжиг в. хөгжим г. театр д. тайз е. дүрслэх урлаг ё. уран зохиол

2.б урлагуудийн нийлмэл бүтээл болох бүжгэн жүжиг нь өөрөө ордны болон ардын бүжгийн хөдөлгөөнөөр дамжин XVII зууны сүүлч XIX эхээр сонгодог хэлбэрээ олсон.

а. кино урлаг б. бүжиг в. хөгжим г. театр д. тайз е. дүрслэх урлаг ё. уран зохиол

2.вурлагаас бүтсэн хөгжмийн зохиолын хамгийн том төрөл болсон симфони найрал хөгжим нь XVIII зууны дундуур бий болсон.

а. кино урлаг б. бүжиг в. хөгжим г. театр д. тайз е. дүрслэх урлаг ё. уран зохиол


8.1.6. Дуурийн үүсэл хөгжил, төрөл хэлбэр, бүтэц, онцлогийг тайлбарлах

1. Дуурийн урлагийн үүсэл болоод анхны дуурийг нэрлэнэ үү.

4а. Дуурийн урлаг нь XVI-XVII зууны зааг дээр үүссэн.

4б. Анхны дуурь Я. Пери, Ринуччини нарын 1597 онд зохиогдсон.....дуурь юм.

2. Хошин ба Төлөв дуурийн Латин нэршлийг нэрлэнэ үү ?



3. Монголын дуурийн урлаг үүсэх үндэс суурь нь хэн гэдэг зохиолчийн ямар нэртэй туужаас эхтэй вэ?

А. Гончигсумлаа “Үнэн”

Б. Данзанравжаа “Саран хөхөөний намтар”

В. Лувсаншарав “Шивээ хиагт”

Г. Наранзэл “Үүлэн заяа”

4. Монголын дуурийн урлагийн түүхэн хуудас ямар уран бүтээлээс эхтэй вэ?

А. Гончигсумлаа “Үнэн”

Б. Данзанравжаа “Саран хөхөөний намтар”

В. Лувсаншарав “Шивээ хиагт”

Г. Б.Смирнов, Б.Дамдинсүрэн “Учиртай 3 толгой”

5. Урлагийн ямар ямар төрлүүдийн нийлэмжээр дуурийн урлаг бий болдог вэ?
Тохирох эмблемд зөөн байрлуулаарай.



Хөгжим
(дуулаач,
дан хөгжим)

Уран
зохиол

Дүрслэх
урлаг

Бүжиг

Кино
урлаг

4 . Египет болон Этиопуудын хоорондын тэмцлийн түүхэн үйл явдлыг харуулсан “ Аида” дуурийн удиртгал “Ялгуусан марш”-ыг анхааралтай сонсож , аялгууны шинж төрхөд тохирохыг сонгоорой.

баатарлаг

түгшүүртэй


баяр хөөртэй

эрч хүчтэй

уйтгартай

8.1.в. Дуурь дах дуулаачийн төрлүүдийг сонсоод ялган таних, үүргийг тайлбарлах

1. Дуурь дах дуулаачийн төрлийг ангилаад, ангилал тус бүр дэх төрлүүдийг нэгтгээрэй.



2 - Д.Лувсаншарав “Шивээ Хиагт ” дуурийн Онолтын ариг сонсож аялгууны тохирох шинж төрх, өнгө аясыг тодорхойлоорой.

ширүүн уйтгар гуниг цөхрөл баяр хөөр харуусал цоглог

♩ = 80

Бу - ян үйл-дэж өр - гол бар - тья бур - хан минь таа - лаж хайр - ла

я - вах га - зар - гүй э - нэ хор - воод

яа - хыг на - дад заа - ж соё - рох бур-хан чи бай-нуу. үгүй юу

бур - хан гэг - дэг байх - гүй ю - муу